

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА
С.ОДОНТУЯАГИЙН ИЛТГЭЛ**

2023.06.12

“ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ”

Хууль эрх зүйн орчин:

Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиудын дагуу иргэд, охид, эмэгтэйчүүдийг тэгш боломжоор хангах, эрхийг нь хамгаалах, нийгэм, гэр бүлд аливаа хэлбэрээр, хүйсээр ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглодог бөгөөд хүйсээс үл хамааран эрх тэгш, нээлттэй хамруулах, хамгаалах зарчмыг баримталж байна.

Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудад хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүйсээр ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглодог бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиуд нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоох, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон эрх зүйн харилцааг зохицуулдаг. Бүх салбар, түвшинд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль хэрэглэгдэж байна.

Манай Улс олон улсын гэрээ, конвенцид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр нэгдэн орж, үндэсний хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг батлан, санаачилга гарган ажиллаж байна.

Тухайлбал, “Эмэгтэйчүүдийн аж байдлын тухай Бээжингийн тунхаглал”, “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенци, “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Женевийн тунхаглалд нэгдэн орсон билээ.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт:

Эмэгтэйчүүд улс нийгэмдээ хөдөлмөр эрхэлж баялаг бүтээхийн зэрэгцээ гэр бүлээ асран хамгаалж, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, улсын болон өрхийн эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулсаар ирсэн. Манай улсын нийт хүн амын 50,9¹ хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. 2022 онд өрх толгойлсон ганц бие эх 66,6 мянга, 18 хүртэлх

¹ ҮСХ, 2021 он

насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 32,0 мянга байна. Ганц бие өндөр настан өрх нийт 47,5 мянга байгаагаас 72,9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 61,6 хувь, нийт ажиллагчдын 46,7 хувь эмэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүдийнхээс 14,9 хувиар бага байгааг харуулж байна. 2022 оны байдлаар манай орны эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 66,4 хувь, эмэгтэйчүүдийнх 51,5%, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 61,5 хувь, эмэгтэйчүүдийнх 48,5 хувьтай байна.

Эмэгтэйчүүд үйлчилгээний салбарын 63,5%, хөдөө аж ахуйн салбарын 22,5%, аж үйлдвэр, барилгын салбарын 14% хувийг эзэлж байна. Түүнчлэн нийгмийн даатгалын санд шимтгэл төлж байгаа 55,4 мянган аж ахуйн нэгж байгууллага байгаагийн 22,3 мянга буюу 40,2 хувь нь эмэгтэй удирдлагатай байна.

Хэдийгээр эмэгтэйчүүд улс орны эдийн засгийн хөгжилд голлох үүрэгтэй оролцож байгаа ч тэдний эд хөрөнгийн эзэмшил хангалтгүй, хөдөлмөрийн үнэлгээ бага байгааг анхаарч, хөдөлмөрийн харилцаанд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн мэдрэмжтэй байх асуудлыг Хөдөлмөрийн хуулийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх болон ажлын байран дээрх эрхийг хангах, хамгаалах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг хангахад чиглэсэн дараах зохицуулалтуудыг тусгасан. Хөдөлмөрийн харилцаанд оролцож буй эмэгтэй ажилтны эрхийг хамгаалах чиглэлээр жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахыг хориглох; хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага, олговор олгох; жирэмсний болон амаржсаны амралт, эцгийн чөлөө; нярай хүүхэд үрчлэн авсан ажилтанд чөлөө олгох, хүүхэд асрах чөлөө олгох; жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг уян хатан нөхцөлөөр ажиллуулах; албан томилолтоор ажиллуулахыг хориглохыг хуульчилсан. Мөн хуульд заасан хөдөлмөрийн гэрээний ажлын бүтэн бус цагаар ажиллуулах, гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах төрлүүд нь эмэгтэйчүүд ажил амьдралын хэмнэлээ зохистой зохицуулах боломжийг олгож байна.

Ажлын байранд ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс ангид байх, зөрчсөн тохиолдолд зохих хариуцлага хүлээлгэх талаар тодорхой заалтыг Зөрчлийн тухай хуульд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр оруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байнгын болон түр ажлын байраар хангах зорилго бүхий “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-үүдийг хэрэгжүүлж байна.

Дээрх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 46.8 тэрбум төгрөгийг зарцуулж ажилласан. Хөтөлбөр, арга хэмжээнд 2022 онд давхардсан тоогоор 85.3 мянган хүн хамрагдсанаас **50.7 мянга буюу 59.5% нь эмэгтэйчүүд** байна. Хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 42.8 мянган ажлын байрыг бий болгож, хадгалснаас 7.8 мянга нь байнгын, 27.3 мянга нь түр, 7.6 мянга нь цагийн ажлын байр байна.

Бага насны хүүхдээ гэртээ асарч буй эмэгтэйчүүдийг дэмжих, гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд цахим болон шаардлагатай ур чадвар олгох, сургалт, дэмжлэгт хамруулах замаар тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг 2022 онд анх удаа батлан хэрэгжүүлж байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллах хүчнээс гадуур байгаа эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд нь тулгарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, тэдэнд болон гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд цахим болон шаардлагатай ур чадвар олгох, сургалт дэмжлэгт хамруулах замаар тэдний орлогыг нэмэгдүүлэхэд зорилготой юм. Тус хөтөлбөрт 2022 онд 3482 хүн хамрагдаж, 556 байнгын болон түр ажлын байр бий болгоход 618.2 сая төгрөг зарцуулжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын 90 орчим хувь нь эмэгтэйчүүд, 10 орчим хувь нь хүүхэд байгаа ба хүчирхийллийн хохирогчийн тоо жилээс жилд, сараас сард өссөөр байна. Шүүхээр ял шийтгүүлсэн нийт ялтны 11,2 хувь буюу нийт 1505 эмэгтэй, 1,7 хувь буюу 228 хүүхэд байна. Иймд Хохирогч эмэгтэйчүүдийг сургаж, ажлын байраар хангах зорилгоор 2023 оноос шинэ арга хэмжээг хэрэгжүүлэх болсон.

Эх, хүүхдэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

2022 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3457.5 мянга², жилийн дундаж өсөлт 2.2 хувь байна. Монгол Улс нь өргөн уудам газар нутагтай, геополитикийн хувьд хоёр том гүрний дунд байрлах манай улсын хувьд хүн амаа өсгөх, хүний хөгжлийг хангах бодлого нь төрийн бодлогын үндэс суурь билээ.

Хүн амын жилийн дундаж өсөлт 2010 онд 1.6 хувь байсан бол 2015 онд 2.1 хувь хүртэл өссөн хэдий ч 2019 онд 0.3 хувиар буурч 1.8 хувь болсон.³ Монгол Улсын хүн

² Статистикийн эмхэтгэл ҮСХ 2015 он

³ Монгол Улсын хүн амын танилцуулга, ҮСХ, 2020 он

амын өсөлтийн хувь 2033 он хүртэл тогтмол аажмаар жилд дунджаар 0.1 пунктээр буурсаар, 2034 оноос эхлэн аажмаар өсөхөөр тооцоологдсон байна.⁴

Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдэд сар бүр тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхийг Эхийн алдар одонгоор урамшуулж жил бүр тэтгэмж олгох зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэн нь амьжиргааны түвшин харгалздаггүй, хүн амын өсөлтөд чиглэсэн бодлого юм.

2022 оны жилийн эцсийн байдлаар насны хишиг тэтгэмжид 168,2 мянган иргэд хамрагдсанаас 96,5 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авсан хүний 98,5 хувь, 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийн 92,4 хувь нь эмэгтэйчүүд байна. Жирэмсэн эхийн тэтгэмжийг 77,6 мянган эхчүүд авч байна. Түүнчлэн эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх,эцэгт олгох тэтгэмжид 283,2 мянга хамрагдсаны 98,8 хувь эмэгтэйчүүд байна.

Монгол Улсад нийт 957.8 мянган өрх байгаагаас 0-18 хүртэлх насны хүүхэдтэй 542,5 мянган өрх байна⁵. Эдгээр хүүхэдтэй өрхийн 65.3 хувь нь 1-2 хүүхэдтэй байна. Иймд дээрх мөнгөн тэтгэмж олгох бодлогоос гадна нэг өрхөд ногдох хүүхдийн тоог нэмэгдүүлэх, хүүхдийн тоотой уялдуулан олон хүүхэдтэй залуу гэр бүлийг урамшуулах, татварын хөнгөлөлт үзүүлэх, орон сууцтай болоход төрөөс дэмжих замаар амьжиргааг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нийгмийн даатгалын тогтолцооны хүрээнд үзүүлэх үйлчилгээгээр тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 30 гаруй нэр төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 6,8 гаруй сая хүнд үзүүлдэг бөгөөд, нийгмийн даатгалын зардал нь дотоодын нийт бүтээгдэхүүний 7 хувьтай тэнцүү байна.

Манай улсын 60-аас дээш настай хүн амын 67,7 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс даруй 9,4 насаар өндөр байна.

Нийгмийн даатгалын тогтолцоонд аливаа тэтгэвэр, тэтгэмж, даатгалын хувь хэмжээг хүйсээр ялгаварлан тогтоох зарчим байхгүй ч гагцхүү эмэгтэйчүүдэд илүү анхаарал тавьж эмэгтэй хүн 55 насандаа, эрэгтэй хүн 60 насандаа тэтгэвэрт гарахаар ялгаатай тогтоосон байдаг. Хэрвээ энэ насаар үзвэл нийт тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн иргэдийн 70 хувь нь эмэгтэйчүүд байна.

Дээрх мэдээллээс үзвэл нийгмийн даатгалаас тэтгэвэр авагчдын ихэнх нь эмэгтэйчүүд байх магадлал өндөр байна. Гэсэн хэдий ч эмэгтэй тэтгэвэр авагчдын

⁴ Монгол Улсын Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, ҮСХ, 2017 он

⁵ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн мэдээлэл, 2023 он.

тэтгэврийн хэмжээ эрэгтэй тэтгэвэр авагчдынхаас доогуур байна. Энэ нь тэтгэврийн тогтолцооноос болж буй бус тэдний хөдөлмөр эрхэлж байсан үедээ авч байсан цалингийн ялгаанаас үүдэлтэй байна.

Гэвч манай улсад тохиож буй хүн амын насжилттай холбоотойгоор 2030 оноос нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин буурч, тэтгэвэр авагчдын тоо өсч, тэтгэврийн даатгалын одоогийн тогтолцоо үйлчилж чадахгүй нөхцөл байдал үүсэхээр байгаатай холбогдуулан бид одоогийн эрэгтэй, эмэгтэй хүний тэтгэврийн насны ялгааг арилгаж адил 65-д хүргэх урт хугацааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эмэгтэй тэтгэвэр авагчид ихэнх хувийг бүрдүүлж, доогуур тэтгэвэр авч байгаатай холбоотойгоор тэтгэврийн зээл авагчдийн ихэнх нь өндөр настай эмэгтэйчүүд байх магадлал өндөр байна. Монгол Улсын Засгийн газраас бүрэн тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн хэмжээг ерөнхийд нь нэмэгдүүлэх, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зэрэг арга хэмжээ авч байгаа нь өндөр настай эмэгтэйчүүдэд эерэгээр нөлөө үзүүлж байна.

Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч зэрэг нийгмийн орлого багатай бүлгийн нийгмийн даатгалд хамрагдалт хангалтгүй байна. Цаг наргүй, байгалийн хатуу ширүүн нөхцөлд ажиллаж амьдардаг малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулахаар шийдвэрлэж, хэрэгжүүлж эхэлснийг малчид таатай хүлээн авч байна.

Охид эмэгтэйчүүдийг чадавхижуулах, хүчирхийллээс хамгаалах талаар

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд жендэрийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүд, охидыг чадавхижуулах талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Манай улс нь жендэрийн тэгш байдлыг хангахад томоохон ахиц гаргаж, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин, дундаж наслалт өссөн ч охид, эмэгтэйчүүдийн талаар анхаарвал зохих дараах асуудлууд байна:

Нэгдүгээрт, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн хувь, 2020 онд УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17.1 хувь байгаа нь дэлхийн дунджаас (2021 оны 1 сард 25.5 хувь) болон Азийн (2021 оны 1 сард 20.4 хувь), үүний дотор Монгол Улс хамаарах Зүүн Азийн (2021 оны 1 сард 21.8 хувь), Төв Азийн (2021 оны 1 сард 24.7 хувь) дунджаас доогуур хэвээр байна.⁶

Хоёрдугаарт, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал. Охид, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах хуулиуд байсаар байтал бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлд эмэгтэйчүүд өртсөөр байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа

⁶ Дэлхийн эдийн засгийн форум “Gender Gap Report”, 2020

гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол Улс дахь хамгийн ноцтой бөгөөд хүний амь насанд аюултай хүний эрхийн зөрчил юм. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн 89,1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гуравдугаарт, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, орлого эрэгтэйчүүдийнхээс бага байсаар байгаа. Эрэгтэй ажилтнуудын ажиллах хүчний оролцоо 66.4 хувь байхад эмэгтэй ажилтнуудын ажиллах хүчний оролцоо 51.5 хувь байна. Цалингийн ялгаа өн удаан оршиж байна. Эрэгтэй ажилтнуудын цалин эмэгтэй ажилтнуудынхаас бараг 20 хувиар дээгүүр байна.

Дөрөвдүгээрт, үл хөдлөх хөрөнгийн эзэмшил, аж ахуй, бизнес эрхлэлтэд эрэгтэйчүүд давуу эрхтэй байна. Ялангуяа хөдөөд орон нутагт эрэгтэйчүүдийн эзэмшил илт давамгайл байна.

Тавдугаарт, өсвөр насны охидын хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт болон бэлгийн замын өвчинд нэрвэгдэх тохиолдол байсаар байна.

Зургаадугаарт, түүнчлэн эмэгтэйчүүд хүүхдээ өгсгөх, гэр бүлийн гишүүдээ асрах зэрэгт илүү хариуцлага хүлээдэг бодит байдал буюу энэхүү угшсан үзэл нь эмэгтэйчүүдийн орлого, шинэ чадвар эзэмших, хөгжих мөн нийгмийн амьдрал дахь оролцоог нь хязгаарлаж байна. Эмэгтэйчүүд улс төр, эдийн засаг, нийгмийн аль ч салбарт тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй, оролцоотой хүмүүс юм.

Иймд, охид эмэгтэйчүүдийг чадавхижуулах талаар цаашид дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна:

- Эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрт эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого, зорилтот хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх
- Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүжилт, хөрөнгө оруулалтын хүртээмжийг нэмэгдүүлэх
- Эмэгтэй бизнес эрхлэгч” гэсэн нэр томъёоллыг тодорхой болгох
- Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн бодлого, шийдвэр хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх. Үүнд, 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-т 5 дугаар зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллаганы хөтөлбөрт туссан зорилтуудыг бодитойгоор хэрэгжүүлэхийг зорин ажиллах.
- Өсвөр насны охид, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлэх, одоогийн боловсрол олгож буй арга барилыг өөрчилж шинэ шатанд гаргах.
- Охид эмэгтэйчүүд өөрийн хүч чадварыг дээшлүүлэх замаар тэгш байдлыг хангах нөхцөлийг бий болгох

- Жөндөрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоож, хүчирхийлэлд өртөгсдөд үр дүнтэй дэмжлэг үзүүлэх, ялангуяа охид эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааг өргөн хүрээгээр хэрэгжүүлэх
- Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэр бүлийн амьдрал дахь үүрэг хариуцлагыг тэнцэржүүлэхэд анхаарч өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, олон нийтэд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах
- Хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах, чадавхижуулах зэрэг болно.

Эмэгтэйчүүд улс нийгэмд, өрхийн түвшинд одоогийн гүйцэтгэж байгаагаасаа ч илүү үүрэгтэй байх боломж нь тэдний чадавхаас ихээхэн хамаарах тул эмэгтэйчүүдийг хүчирхийллээс ангид байлгаж, чадавхижуулах нь нийгмийн хөгжлийн нэг чухал гарц мөн.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

--oOo--